

Япон Зvнн Хятадын тэнгисийн маргаан vвсгэсэн Дяоюйдао (Сенкаку) арлуудыг улсын мэдэлд авсныг эсэргvвцсэн тэмцэл ходолгоон Хятадад эрч хvчээ авч байна. Үvний хариуд Токио хvч хэрэглэх ажиллагааг зогсоож, эдгээр арал аюулгvй байдлын тухай япон-америкийн гэрээний вйл ажиллагаанд хамрагдаж байгааг анхааруулав.

Гэвч Хятадад эсэргvвцэл гаарч байна. Очигдор тус улсын бараг 60 хотод Японы эсрэг жагсаалд наанадаж 100 мянган хvн оролцов. Хамгийн оргон цар хvрээтэй тэмцэл ходолгоон Шэньжэн, Гуанжоуд болжээ. Тэнд японы капитал чухал байр суурь эзлэсэн. Эдгээр хоёр хотын гудамжуудад тус тус 10 мянган хvн гарав. Эсэргvвцэгчид японы бараа таваарын дэлгvвр, японы хоол ундны ресторануудыг устгав. Улс даяар «Тойота», «Ниссан», «Хонда» авто концернуудын толоологчдийн газруудын дэргэд 100 гаруй машиныг шатаажээ. Шэньжэнд цагдаа нартай морголдэв. Тэд ус шурших тохоорэг, нулимс асгаруулах хий хэрэглэжээ.

«Хятадыг хамгаалая!», «Японы милитаризм соногтvн!», «Японы бараа таваарыг худалдан авахаас татгалзая!» гэж оноодор жагсагчид Бээжинд суугаа Японы элчин сайдын яамны дэргэд хашгирав. «Манай арлуудыг булаан эзлэсэн япон чотгорийг» шийтгэх уриа лоозон сонсогдов. Нар мандах дэвсгэрт тарган гахай зурсан зурагт хуудас харагдав. Японы элчин сайдын яамны байшин руу устай лонх, ондог шидсэн байна.

Үvний хариуд Бээжин Гуанжоу, Шэньжэн дахь японы сургууль, вйлдвэрийн газрууд ажлаа наанадаж лхагва гариг хvртэл тур зогсоов. Тухайлбал Canon, Panasonic компаниудын вйлдвэрvвдийг хаажээ. Онгорсэн амралтын одрvвдэд Panasonic пуусийн гурван вйлдвэрт нэг зэрэг халдав. Нэгэн вйлдвэрийг бараг бvрмосон устгаж, хэсэглэчилэн шатаав. Мэргэжилтнvвд хохиролын хэр хмжээг тогтоосны дараа л эдгээр вйлдвэр ажлаа сэргээнэ.

Хоёр талын харилцааг хэвийн болгосноос хойш 40 жил онгорсний дараа харилцаа урьд омно vзэгдээгvй аюултай хурцдсан гэж Алс Дорнодын хvрээлэнгийн шинжээч Валерий Кистанов хэлээд: «Японы эсрэг тэмцэл ходолгоон хэр удаан vргэлжлэхийг хэлэхэд хэцvв.

Байдал дайн дэгдээх хүртэл даамжрахгүй. Талууд маргааны хүрээнд байлдааны биш эргүүлтийн холог онгоцуудыг хэрэглэж байгаа нь морголдоонийг тогтоон барих хүслийг тусган харуулав. Зэвсэгт хүчин хэрэглэх нь хямралыг гааруулах оор ve шат болж мэднэ» гэв.

Байдлаас харахад оноодор японы удирдлага япон-хятадын харилцаа хурцдсан асуудлыг АНУ-ын БХ-ын сайд Леон Панеттатай хэлэлцсэн байна. Арлуудын тойрны байдал аюулгүй байдлын тухай япон-америкийн гэрээний вйл ажиллагаанд хамрагдаж байна гэж Японы ГХЯ-ны тэргүүн Коитиро Гэмба уулзалтын дараа мэдэгдэв. Бvр 1960 онд гарын үсэг зурсан гэрээ Японд халдан довтлосон хэрэг явдлыг оорий нь үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн хэрэг хэмээн үзэх боломж АНУ-д олгов.

Энэ нь Токио АНУ хоёроос хийсэн ийн анхны мэдэгдэл биш. Вашингтон хоёр талын маргаанд хондлонгоос оролцож байна гэж Бээжин үзэж, эрс хатуу хариу огч байна. Иймээс Японы ГХЯ-ны тэргүүний мэдэгдэл Хятадад үндэсэрхэг үзэл санааг гааруулж, тэмцэл ходелгоонийг шатлан оргожvүлж болзошгүй. Хятадын тал Пентагоны тэргүүн Бээжинд айлчлах veэр үүнийг тайлбарлахыг шаардах бололтой. Панетта Токиогоос Бээжинд очих юм.

Айлчлалын протоколыг одоогоор зарлан мэдээлээгүй боловч ажиглагчид БНХАУ-ын дэд дарга Си Зиньпин 10 одор харагдахгүй байснаа онгорсон амралтын одрүүдэд нийт олны омно гарч ирсэнд анхаарлыг хандуулав. Тэрээр 9-р сарын 4-нд АНУ-ын Торийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтонтэй хийх уулзалтаа болиулсан билээ. Си Зиньпинийг Ху Зиньтаогийн залгамжлагч хэмээн үздэг. Америкийн талаархи мэргэжилтэн хэмээн шинжээчдийн үзэж байгаа Си Зиньпин л Японтой санал зорсөн асуудлаар Хятадын байр суурийг Леон Панеттад мэдээлэх байх.